

# КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2022 оны 12 сарын 28-ны өдөр

№ 22/19

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*“Ард Бит” ХХК-ийн хувьцааг худалдан авах,  
Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.17, 76.1.18 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, Крипто Үндэстэн ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, ТУЗ-ийн 2022 оны 12 сарын 28-ны өдрийн эчнээ санал хураалтын дунг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**:

1. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн 100%-ийн охин компани “Ард Бит” ХХК-ийн гаргасан бүх хувьцаа болох нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,000,200 (хоёр сая хоёр зуун мянга хоёр зуу) ширхэг хувьцааг 200,020,000 (хоёр зуун сая хорин мянга) төгрөгөөр “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-иас худалдан авсугай.
2. Компанийн тухай хуульд заасны дагуу энэ Тогтоолоор шийдвэрлэсэн асуудлаар сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүд санал хураалтад оролцоогүй болохыг дурдсугай.
3. Тогтоолд заасан нөхцөлөөр “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-тай Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Хувьцааны эрх шилжүүлэх гэрээг тус тус байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах, хувьцааны төлбөрийн нөхцөл, хуваарийг тохирох эрхийг Гүйцэтгэх захирал Д.Чадраабал-д олгосугай.
4. Компани нь “Ард Бит” ХХК-ийн хувьцааг бүхэлд нь худалдан авсантай холбогдуулан тус компанийн дүрмийг Хавсралт 1-ээр шинэчлэн баталсугай.
5. “Ард Бит” ХХК-ийн гүйцэтгэх захирал, бүртгэлтэй хаягийг хэвээр үлдээсүгэй.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, эрх бүхий байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэхийг Гүйцэтгэх захирал Д.Чадраабал-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.ГАНХУЯГ



# КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2022 оны 12 сарын 28-ны өдөр

№ 22/10

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*“Ард Венчурс” ХХК-ийн хувьцааг худалдан авах,  
Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.17, 76.1.18 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, Крипто Үндэстэн ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, ТУЗ-ийн 2022 оны 12 сарын 28-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн 100%-ийн охин компани “Ард Венчурс” ХХК-ийн гаргасан бүх хувьцаа болох нэг бүр нь 10,000 (арван мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 (нэг зуу) ширхэг хувьцааг 1,000,000 (нэг сая) төгрөгөөр худалдан авсугай.
2. Компанийн тухай хуульд заасны дагуу энэ Тогтоолоор шийдвэрлэсэн асуудлаар сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүд санал хураалтад оролцоогүй болохыг дурдсугай.
3. Тогтоолд заасан нөхцөлөөр “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-тай Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Хувьцааны эрх шилжүүлэх гэрээг тус тус байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах, хувьцааны төлбөрийн нөхцөл, хуваарийг тохирох эрхийг Гүйцэтгэх захирал Д.Чадраабал-д олгосугай.
4. Компани нь “Ард Венчурс” ХХК-ийн хувьцааг бүхэлд нь худалдан авсантай холбогдуулан тус компанийн дурмийг Хавсралт 1-ээр шинэчлэн баталсугай.
5. “Ард Венчурс” ХХК-ийн гүйцэтгэх захирал, бүртгэлтэй хаягийг өөрчлөхгүй болохыг дурдсугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, эрх бүхий байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэхийг Гүйцэтгэх захирал Д.Чадраабал-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.ГАНХУЯГ

